



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2018 оны 11 дүгээр
сарын 02-ны өдөр

Дугаар 179

Улаанбаатар
хот

Ажлын хэсэг байгуулах тухай

1. Замын-Үүдийн чөлөөт бүсэд БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр баригдсан цэвэр, бохир усны барилга байгууламж, 90 МВт-ын хүчин чадал бүхий дулааны станцыг хүлээн авах, цаашдын ашиглалтын талаар судлан санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ажлын хэсгийн
ахлагч

-Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин

Гишүүд:

-Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар;

-Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
Н.Цэрэнбат;

-Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан;

-Зам, тээврийн хөгжлийн сайд Я.Содбаатар;

-Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн;

-Дорноговь аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин.

Нарийн бичгийн
дарга

-Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын дарга
Н.Цагаанхүү.

2. Асуудлыг судлан санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсэг (Ө.Энхтүвшин)-т даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ